

АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I.ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

- Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан
- Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Их сургуулийн дүрэм
(2022.05.24)

Дагаж мөрдөх огноо:

2022.05.24

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:

Байгууллагын нэр:

Дотоод хэргийн их сургууль

Нэгжийн нэр:

Сургалт, эрдэм шинжилгээний газар

Албан тушаалын нэр:

Багшийн хөгжлийн төвийн эрхлэгч

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

ТТ-15

Ажлын цаг:

8 цаг

Ажлын байрны албан ёсны байршил:

Баянзүрх дүүрэг, 8 дугаар хороо
Хилчний гудамж

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

Онцгой нөхцөл:

Хуулиар хүлээсэн бусад үүргийг
хэрэгжүүлэх

II.АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Их сургуулийн эрхэм зорилго, зорилттой уялдуулан багшийн хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх, багшийн хөгжилд чиглэсэн үйл ажиллагааны урт, богино хугацааны төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилт, явц байдал, биелэлт, үр дүнг тооцон, дүн шинжилгээ хийх, цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааны үндсэн чиглэлийг тодорхойлох.

Албан тушаалын зорилт:

- Их сургуулийн эрхэм зорилго, зорилт, стратегийн болон үйл ажиллагааны төлөвлөгөөтэй уялдуулан багшийн хөгжлийн хөтөлбөр, үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх;
- Их сургуулийн багшийн хөгжлийн хэрэгцээ шаардлагыг судлах, багш хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны явц байдал, үр дүнд боловсруулалт хийж, үнэлгээ дүгнэлт өгөх зэрэг багш хөгжлийн төвийн ажлын чиг үүрэг, бодлого төлөвлөлтийг боловсруулж, хэрэгжүүлэх, санал танилцуулахад их сургуулийн багш нар болон төвийн албан хаагчдыг мэргэжил, арга зүйн чиглэлээр хангах, үйл ажиллагаанд хяналт тавих, зөвлөн чиглүүлэх;
- Бүрэлдэхүүн сургуулийн багш, ажилтны үндсэн мэдээллийн сан бүрдүүлэх, багш мэргэжлийн мэдлэг, заах арга зүй- ур чадвар, ёс зүй- харилцааны асуудлаар хөндлөнгийн шинжилгээ хийх, зөвлөгөө өгөх;

4.Салбарын боловсрол судлалын хөгжүүлэх, багш нарт зохион байгуулалтын болон арга зүйн дэмжлэг үзүүлэх.

5.Хариуцсан сургууль, нэгжийн албан хаагч, ажилтны хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг хангах, тэдний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, эрсдлийн удирдлагын манлайллыг хэрэгжүүлж, эрсдлийг удирдах

6.Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж, их сургуулийн үнэт зүйлийг эрхэмлэн дээдлэх, Их сургуулийн удирдлагаас албан тушаалын зорилгод нийцүүлж хариуцуулсан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага оролцооны хэлбэр Туслах –Т Хариуцан гүйцэтгэх –Г Хянах –Х Шийдвэрлэх -Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	1.1.Их сургуулийн багшийн хөгжлийн талаарх үндсэн чиглэл, бодлогын дагуу хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулж, биелэлтийг хангаж ажиллах; 1.2.Бүрэлдэхүүн сургууль, тэнхим, багш нэг бүрээр багшийн хөгжлийн төлөвлөгөөг гаргуулан, хэрэгжилтийг хангуулах; 1.3.Багш, ажилтныг хөгжүүлэх талаар шаардлагатай саналыг боловсруулах, шийдвэрлүүлэх; 1.4.Багш нарын судалгаанд үндэслэн, сургалтын ачаалал тооцож, сургалт, зөвлөгөөний хөтөлбөртэй уялдуулах;	Их сургуулийн багшийн хөгжлийн үндсэн чиглэл, хөтөлбөр, сургалт зөвлөгөөний төлөвлөгөө урт богино хугацаагаар төлөвлөгдсөн байна.	Х, Г Х, Г Х, Г Ш, Х
2 дугаар зорилтын хүрээнд	2.1.Багш хөгжлийн үндсэн болон зорилтот хөтөлбөрийг, танилцуулах, сурталчлах, биелэлтийг хангах ажлыг зохион байгуулах; 2.2.Багшийн хөгжлийг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлэх, тайлагнах, үр дүнг тооцох; 2.3.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд хяналт тавих; 2.4.Хөтөлбөрийн хэрэгжилтэд урт болон дунд хугацааны үнэлгээ хийх; 2.5.Багшийн хөгжлийн дэмжих шаардлагатай сургалт, семинаруудыг зохион байгуулах;	Багшлах бүрэлдэхүүнийг эрдэмжүүлэх, мэдлэг үр чадварыг дээшлүүлэх зорилт хэрэгжиж, үр дүнтэй сургалтын тогтолцоо бүрдэнэ.	Х, Г Х, Ш, Х Х, Т Х, Т
3 дугаар зорилтын хүрээнд	3.1.Багш нарын хөгжлийн болон сургалтын хэрэгцээ шаардлагыг судлах;	Багш нарын	Х, Т

	3.2.Шинэ залуу багш нарыг заах арга зүйн болон мэргэжлийн давтан сургалтад хамруулах; 3.3.Багшийн хичээлд сууж, арга зүйн зөвлөгөө өгөх; 3.4.Сургалтын цахим хэлбэрийг өргөнөөр нэвтрүүлэх;	ажлын арга барил, мэдлэг, ур чадвар сайжирна.	Х, Т Х, Г Х, Т Т, Х
	4.1.Сургалтын сэтгэл ханамжийн судалгаа авах; 4.2.Тэргүүний багш шалгаруулах;		Т, Г Г, Х
4 дүгээр зорилтын хүрээнд	4.3.Их сургуулийн багш нарын аттестатчиллыг үе шаттай зохион байгуулах; 4.4."Г" багц цагийн гүйцэтгэлийг хянах; 4.5.Багш нарын хичээлд үнэлгээ өгөх үнэлгээний шалгуур хуудас боловсруулах;	Албан хаагчийн сахилга, ажлын хариуцлага сайжирч, байгууллагын соёл төлөвшинө.	Х, Т Т, Г Г,Х
5 дугаар зорилтын хүрээнд	5.1.Албан хаагчийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг хангах, хууль тогтоомжоор хүлээсэн бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй нь холбогдуулж, тэдэнд учирч болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах; 5.2.Албан хаагчийн хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээг нэгдсэн удирдлагаар хангах; 5.3.Албан хаагчдын сахилга, ёс зүйн байдлын хяналт-шинжилгээний дүнг үндэслэн гэмт хэрэг, эрх зүйн зөрчилд холбогдохоос урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах; 5.4.Сургууль, нэгжийн хэмжээнд эрсдлийн удирдлагын манлайллыг хэрэгжүүлж, эрсдэлийг удирдах; 5.5.Чанарын менежментийн тогтолцоог хэрэгжүүлэх, нутагшуулах, соёлыг төлөвшүүлэх үйл ажиллагааг удирдлага зохион байгуулалтаар хангах;	Хөдөлмөрийн аюулгүй байдал, алба хаагчийн эрх ашиг хамгаалагдана.	Х, Т Х Х, Г Х, Г Х, Ш
6 дугаар зорилтын хүрээнд	6.1.Их сургуулийн алсын хараа, эрхэм зорилго, үнэт зүйлсээ дээдэлж, албандаа хүндэтгэлтэй хандах; 6.2.Их сургуулийн хэмжээнд мөрдөгдөх эрх зүйн актуудыг чанд мөрдөн ажиглах; 6.3.Ажлаа хичээлийн болон хуанлийн жил, улирал, сараар төлөвлөж, хэрэгжилтийг ханган тухай бүр тайлагнах;	Албан хаагчийн сахилга, ажлын хариуцлага сайжирч, үнэт зүйлсээ дээдэлсэн байгууллагын соёл төлөвшинө.	Г Г Х, Г

	<p>6.4.Хамт олны дунд зэрэг уур амьсгалыг бүрдүүлж, бие биедээ хүндэтгэлтэй хандах зарчмыг баримтлах;</p> <p>6.5.Албан үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай өөрийн мэдлэг, ур чадварыг байнга дээшлүүлж, хийсэн ажлынхаа гүйцэтгэл, үр дүнгийн төлөө хариуцлага хүлээх чадвартай байх;</p> <p>6.6.Хүлээсэн үүрэгтээ үнэнч байж, нийтийн ашиг сонирхолд захирагдаж, ашиг сонирхлын зөрчилд автахгүй байх, хууль бус, шударга бус явдалтай эвлэрдэггүй байх;</p> <p>6.7.Суралцагч болон удирдлагадаа ажиллаж байгаа албан хаагч бүртэй алагчлалгүй харьцаж, хөгжилд өөрийн хувь нэмрийг оруулах;</p> <p>6.8.Их сургуулийн Албаны бэлэн байдал болон цэрэгжил ч, жагсаалч байдлыг хангаж, бие бялдрын өв тэгш хүмүүжилтэй байх;</p> <p>6.9.Биеийн эрүүл мэнд, бие бялдраа албаны шаардлагад нийцүүлэн хөгжүүлэх;</p> <p>6.10.Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг хугацаанд нь бүрэн хангаж танилцуулах;</p> <p>6.11.Төрийн албан хэрэг хөтлөх заавар, стандартыг чанд баримтлах.</p>		<p>Г</p> <p>Х, Г</p> <p>Г</p> <p>Г</p> <p>Г,Т</p> <p>Г</p> <p>Г</p> <p>Г</p>
--	--	--	--

III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол	Доктор	
Мэргэжил	0114 Багш – судлаач	
Мэргэшил	Боловсрол судлал	
Туршлага	Боловсролын байгууллагад 10-аас доошгүй жил, дэд профессор түүнтэй адилтгах албан тушаалд 4-өөс доошгүй жил ажилласан байх;	
Ур чадвар	Удирдан зохион байгуулах	- Шийдвэр гаргах, үнэлгээ дүгнэлт өгөх, сургалт зохион байгуулах, хичээл заах, онол, арга зүйн зөвлөгөө өгөх.
	Дүн шинжилгээ хийх	- Судалгаа шинжилгээ хийх, баримт бичиг боловсруулах, үр дүнг тооцох.
	Асуудал шийдвэрлэх	- Мэргэжлийн зөвлөгөө өгөх.
	Манлайлах	- Багаар ажиллах, ачаалал даах, харилцааны ур чадвартай.
	Бусад	- Боловсрол судлалын шинжлэх ухааны онолын болон арга зүйн судалгаа шинжилгээ хийх ур чадвартай.

IV. АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:

- Сургалтын бодлого, төлөвлөлтийн газрын дарга

Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо:

1. Судалгаа шинжилгээ, шинжилгээ, үнэлгээний менежер
2. Сургалт арга зүйн менежер

Бусад харилцах субъект:

Бүрэлдэхүүн сургууль, бүтцийн нэгжүүдийн холбогдох албан тушаалтнуудтай харилцах;

V. АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

Албан тушаалын тодорхойлолт боловсруулсан:

Албан тушаал:

Захиргааны удирдлагын газрын захирал, цагдаагийн хурандаа

Б. Эрдэнэбат

2022 оны 06 дугаар сарын 10-ны өдөр

Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:

Байгууллагын нэр:

Шийдвэрийн огноо:

Дугаар:

Албан тушаалын тодорхойлолт баталсан:

Байгууллагын нэр: Дотоод хэргийн их сургууль

Шийдвэрийн огноо:

Дугаар:

Дотоод хэргийн их сургуулийн захирал, доктор (Ph.D), профессор, цагдаагийн хурандаа

П. Батбаатар

2022 оны 06 дугаар сарын 10-ны өдөр

